



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ДОТООД АУДИТЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2024 оны 05 сарын 24 өдөр

Дугаар 03

Сүхбаатар сум

Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газрын 2022-2023 оны үйл ажиллагаанд хийсэн санхүүгийн хяналт шалгалтын дүнгийн тухай

Төсвийн тухай хуулийн 69.3, Монгол улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 7.7, Сангийн Сайдын 2019 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын хорооны дүрэм”-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалтыг үндэслэн Сангийн Сайдын баталсан нэгдсэн удирдамжаар Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газрын 2022, 2023 оны үйл ажиллагаанд хийсэн санхүүгийн хяналт шалгалтын дүнг хорооны хурлаар хэлэлцээд ТОГТООХ нь:

Нэг. Сангийн Сайдын баталсан нэгдсэн удирдамжаар Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газрын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтын эрсдэлийн үнэлгээгээр “**Бара**” эрсдэлтэйд тооцож, төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн гаалийн бүрдүүлэлт, эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагааны горимыг баримталж ажилласан байна гэсэн дүгнэлтийг баталсугай.

Хоёр. Санхүүгийн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг улсын байцаагчийн өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг тогтоосон хугацаанд Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд тайлагнахыг Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Өнөболдод хариуцуулсугай.

Гурав. Дотоод аудитын хорооны тогтоолыг аудитын тайлан, санхүүгийн хяналт шалгалтын танилцуулга, ажлын баримтуудын хамт Сангийн Яамны санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газарт болон холбогдох албан тушаалтанд хүргүүлж тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитын хорооны нарийн бичгийн дарга (Т.Мөнхзул)-д үүрэг болгосугай.

Дөрөв. “Санхүүгийн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээний хэрэгжилтийн биелэлтийг 3 улирлын ээлжид хуралдаанаар танилцуулахыг Санхүүгийн хяналт дотоод аудитын албаны дарга (Т.Одсүрэн)-д даалгасугай.

Хорооны дарга:  Н.Луувадорж
(Аймгийн Засаг дарга)

Нарийн бичгийн дарга:  Т.Мөнхзул
(Ахлах дотоод аудитор)

4324009003


Гишүүд:



Т.Одсүрэн
(Санхүүгийн хяналт, дотоод
аудитын албаны дарга)



Ө.Сувдаа
(Аймгийн Засаг даргын
Тамгын газрын дарга)



Х.Мөнхжаргал
(Санхүү төрийн сангийн хэлтсийн
даргын албан үүргийг түр орлон
гүйцэтгэгч)



А.Дашбат
(Иргэний төлөөлөл)